

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 12 ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот


Ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах,
зарим эд хөрөнгөд дахин үнэлгээ хийхийг зөвшөөрөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 31 дүгээр зүйл, компанийн тухай хуулийн 76.1.16, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2016 оны санхүүгийн аудитын зөвлөмжийн дагуу ашиглалтын хугацаа дуусч, цаашид ашиглалтын болон техникийн шаардлага хангахгүй болсон анхны өртөг нь 42 924 457,37 /дөчин хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун тавин долоон төгрөг гучин долоон мөнгө/ төгрөгийн балансын бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй 54 ширхэг эд хөрөнгийг актлаж, данснаас хасах саналыг нэгдүгээр хавсралтаар, ашиглалтын хугацаа дууссан боловч одоо ашиглаж байгаа 318 нэр төрлийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг хоёрдугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

2.Компанийн 2016 оны санхүүгийн аудитын зөвлөмжийн дагуу ашиглалтын хугацаа дууссан актлах хөрөнгийн холбогдох материалыг бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх, ашиглалтын хугацаа дууссан боловч одоо ашиглаж байгаа эд хөрөнгөнд дахин үнэлгээ хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Балдорж/ үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ЧИМЭДДОРЖ